

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/97/СТА-ТӨХК

Агуулга

Агуулга	1
1 Аудитын гэрчилгээ.....	2
2 Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудин явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.9. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3 Менежментийн захидал	11
2 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.БАЯРСАЙХАН ТАНАА

2019.03.20 № 06/523
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай, нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 18-наас 2019 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Болорцэцэг, бүртгэл санхүүгийн ахлах мэргэжилтэн Ш.Оюунчимэг, мэргэжилтэн Б.Солонготуяа нар хэрэгжүүлэв.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 2/362 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон ерөн нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК нь Улаанбаатар хотын найман дүүрэг, Төв аймгийн 16 сумын нутаг дэвсгэрийн 307,000 гаруй хэрэглэгч буюу Монгол Улсын нийт хүн амын 50 шахам хувийг цахилгаан эрчим хүчээр хангах үйл ажиллагаа эрхэлдэгээрээ эрчим хүчний дотоодын зах зээлд томоохон байр суурийг эзэлдэг байна "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судаллаа.

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК нь Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д "Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг" гэсэн хуулийн заалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай
- Агаарын бохирдлын хөтөлбөрийн тухай
- Агаарын тухай
- Барилгын тухай
- Компанийн тухай
- Галын аюулгүй байдлын тухай
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- 2018 оны 6 дугаар сарын 7-нд Төсвийн тухай хуулийн 24.6-д *“Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”, 24.1-д “Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийлбэрээс бүрдэнэ”* тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.
- 2018 оны 01 дүгээр сарын 12-нд Агаарын бохирдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7-д *“Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна”, 29 дүгээр зүйл “Агаарын бохирдлын эсрэг сан” 29.1-д “Агаарын бохирдлын эсрэг сан /цаашид “сан” гэх/-гийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна”, 29.2-д “Сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна”, 29.3-д “Сан нь түүний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх орон тооны бус Удирдах зөвлөлтэй байна”, 29.4-д “Энэ хуулийн 29.3-т заасан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд томилно”, 29.5-д “Энэ хуулийн 29.3-т заасан Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.” 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн алба” гэснийг “бүх шатны Засаг дарга мэргэжлийн албатай хамтран” гэж тус тус өөрчлөлт орсон байна.*

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого журамтай нийцсэн байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нийт хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаатай холбоотой юм.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 41,986.2 сая төгрөг бөгөөд түүний 0.1 хувь болох 419.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцох хувийг 1 хувиар тооцсон нь материаллаг байдлын суурийг тооцохдоо нийт зардлыг суурь болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг гүйцэтгэх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	393.5	4 чиглэлд өгсөн зөвлөмж нь дансны ангилалыг зөв болгох, зөв тооцоолох зэрэг зөрчлүүдэд зөвлөмж өгсөн.
	Дүн	4	393.5	

2.9. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулан тэмдэглэв.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 4 дүгээр сарын 09-ний 57 дугаар тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн арилжааны банкуудын зээлийн хүүг судлан Голомт банкттай 17,000.0 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулсан байна. Энэхүү зээлээр бүтээн байгуулсан хөрөнгө, түүний гүйцэтгэл, эцсийн шийдвэрийг нягтлан шалгах, төсөл хөтөлбөрөөр гүйцэтгэж байгаа ажлын үр дүн гүйцэтгэлийн талаар дараагийн аудитад хамруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь тайланд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хөрөнгийн дахин үнэлгээг зохион байгуулж нийт 87,205.84 мкв газрыг 2,119.3 сая төгрөгөөр, бүрэн орлуулалтын аргыг ашиглан 468 ширхэг 15,088.1 сая төгрөгийн анхны өртөгтэй барилгын бодит үнэ цэнийг 20,625.2 сая төгрөгөөр тооцон, 7,671.0 сая төгрөгөөр дахин үнэлгээг нэмэгдүүлж, 213 ширхэг 19,062.3 сая төгрөгийн анхны өртөгтэй барилгын бодит үнэ цэнийг 4,728.7 сая төгрөгөөр тооцон, 8,101.6 сая төгрөгөөр дахин үнэлгээг бууруулсан байна. Нийт 430.6 сая төгрөгийн дахин үнэлгээний бууралтыг хөрөнгийн үнэлгээний “МЧД” ХХК-ийн Монгол улсын мэргэшсэн үнэлгээчин Ч.Дарамбазар нягтлан шалгалтаар баталгаажуулсан байна. 2016 оноос хойш ашиглалтанд орсон 276 ширхэг барилга дахин үнэлэгдээгүй. Дахин үнэлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авч, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

2018 оны 10 дугаар сараас 3 дугаар сарын хооронд Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд 1,244.1 сая төгрөгийн цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлж, өссөн дүнгээр Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас авах 3,828.1 сая төгрөгийн авлага үүсээд байна. Энэ нь нийт авлагын 76 хувийг эзэлж байна.

2.11. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит байгууллагын удирдлага нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой арга хэмжээнд зориулан 2018 онд 388,392.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсвөөс нийт 421,191.3 сая төгрөгийн орлого олж, төлөвлөгөөнөөс 8.44 хувиар буюу 32,798.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь борлуулалтын орлогыг 30,218.1 сая төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 1,905.8 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Компанийн дүнгээр 2018 онд нийтдээ 386,131.9 сая төгрөг зарцуулахаас 314,325.7 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт, 66,406.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд, 5,399.8 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 8.9 хувиар буюу 34,531.9 сая төгрөгөөр илүү буюу нийт 420,663.8 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 344,288.5 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт, 70,934.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд, 5,449.1 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн

жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Компанийн шилэн дансны ажлын хэсэг нийт 7 төрлийн мэдээллийг сар, улирал, жилээр нь цаг хугацаанд нь байршуулан ажилласан байна. Компани нь өөрийн вэб хуудсан дахь шилэн дансны мэдээлэлд тайлант жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 267 нэр төрлийн нийт 14,886.8 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулсан. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 10,299.8 сая төгрөг, харьцуулалтаар 4,158.3 сая төгрөг, шууд худалдан авалтаар 428.7 сая төгрөгийн худалдан авалтыг хийхээр мэдээлсэн байна.

Хуулийн хэрэгжилтэд компанийн худалдан авах ажиллагааны хэлтсийн дотоод аудит, Эрчим хүчний яам тогтмол хяналт тавьдаг байна.

Эрчим хүчний яамны Дотоод аудитын хэлтсээс Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансыг хөтөлж, холбогдох 7 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж байгаа эсэх талаар шалгалт хийж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд зөрчилгүй үнэлгээ өгсөн байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 100 хувь хэрэгжүүлж биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 1/1776 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. “Авлагын данстай холбоотой асуудал”

3.1.1. Илрүүлэлт

Гэрээний хугацаа дууссан, насжилт өндөртэй 223.3 сая төгрөгийн авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*; 14.2.3-д *“Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* заалттай нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл

Үр ашиггүй зардал гаргах, найдваргүй авлага бий болох эрсдэлтэй байна.

3.1.3. Өгсөн зөвлөмж

Ажил гүйцэтгэлийн хяналт, ажил хүлээлцэх удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах зөвлөмж өгөв.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.2. “Балансын данстай холбоотой асуудал”

3.2.1. Илрүүлэлт

Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэлтэй 10 харилцагчийн гэрээний хугацаа, ажил үйлчилгээ хийгдээгүй 87.2 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд дансны ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “*Үнэн зөв байх*” заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

3.2.2. Эрсдэл

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах,

3.2.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.3. “Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал”

3.3.1. Илрүүлэлт

Тайлант онд нэмэгдсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг дахин тооцоолоход 34.9 сая төгрөгийн зардлыг илүү, 2.8 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцож, нийт 32.2 сая төгрөгөөр тайлант үеийн зардлыг нэмэгдүүлж, үр дүнг бууруулсан нь ААНОАТ-ын тухай хуулийн 13.10-т “*Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараа улиралын эхний өдрөөс эхлэн тооцно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “*Үнэн зөв байх*” заалтыг тус тус зөрчсөн байна.

3.3.2. Эрсдэл

Үр дүнг бууруулж, санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл хүрэх,

3.3.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, тооцооллыг хууль, журамд нийцүүлэн засаж, ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.4. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлантай холбоотой асуудал”

3.4.1. Илрүүлэлт

Тус компани нь Нэмэгдсэн өртгийн албан татварт тайлагнах орлого 50.8 сая төгрөгийг /*маягт-ТТ03А*/ 13 дугаар мөр (*цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга,*

шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ үзүүлсний орлого)-нд бөөн дүнгээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалттай нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл

Татварын орлого бодитоор тайлагнагдахгүй байх,

3.4.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, батлагдсан маягтын дагуу үнэн зөв ангилан тайлагнаж байх зөвлөмж өгөв.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,925,723,730.03	1,879,394,265.48
1.1.2	Дансны авлага	21,013,433,058.83	24,719,680,020.94
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	374,951,749.10	475,952,772.64
1.1.4	Бусад авлага	3,229,022.40	5,026,543,251.14
1.1.6	Бараа материал	8,486,533,695.90	8,915,700,404.81
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	791,355,454.12	167,836,309.25
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	38,821,020,122.48	41,185,107,024.26
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	197,649,369,501.70	218,005,813,272.90
1.2.2	Биет бус хөрөнгө	880,509,327.89	848,027,724.50
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,548,177,086.04	17,682,980,980.66
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	202,078,055,915.63	236,536,821,978.06
1.3	Нийт хөрөнгийн дүн	240,899,076,038.11	277,721,929,002.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	11,453,011,518.63	16,597,318,544.27
2.1.1.2	Цалингийн өглөг	3,759,297,061.00	3,353,892,047.62
2.1.1.3	Татварын өр	215,015,977.09	141,470,575.55
2.1.1.4	НДШ - ийн өглөг	488,708,617.93	106,956,514.66
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	13,972,026,882.94
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	660,258,000	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,503,946,920.41	1,300,769,732.07
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,318,553,212.21	4,090,132,036.99
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	21,398,791,307.27	39,562,566,334.10
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	37,934,594,771.61	35,580,206,764.35
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,381,584,190.90	2,729,745,174.97
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,213,210,583.02	17,054,323,641.73
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	43,529,389,545.53	55,364,275,581.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	64,928,180,852.80	94,926,841,915.15
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч	80,764,538,429.43	80,760,025,198.32
2.3.1	-төрийн	80,764,538,429.43	80,760,025,198.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	49,883,227,880.90	49,200,009,387.70
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	38,961,571,729.39	46,490,442,918.61
2.3.9	Хуримтлагдсан ашиг	6,361,557,145.93	6,344,609,582.54
2.3.11	Эздийн өмчийн дүн	175,970,895,185.31	182,795,087,087.17
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	240,899,076,038.11	277,721,929,002.32

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

СТ-2А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	355,506,428,690.30	412,752,286,311.54
2	Борлуулалтын өртөг	320,257,396,397.89	378,686,128,781.12
3	Нийт ашиг (алдагдал)	35,249,032,292.41	34,066,157,530.42
4	Түрээсийн орлого	64,236,654.51	50,841,036.36
5	Хүүний орлого	191,316,700.87	147,521,794.83
8	Бусад орлого	7,213,693,883.33	8,240,724,206.58
9	Борлуулалт, маркетингийн зардал	23,865,024,074.46	25,109,786,815.73
10	Ерөнхий ба удирдлагын зардал	9,504,796,750.29	11,293,655,576.58
11	Санхүүгийн зардал	140,028,357.11	133,636,592.51
12	Бусад зардал	5,065,310,905.68	5,449,134,366.66
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(19.966.40)	91,710.85
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,143,098,811.18	519,122,927.56
19	Орлогын татварын зардал	704,504,202.17	362,913,163.56
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	3,438,594,609.01	156,209,764.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,438,594,609.01	156,209,764.00
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	3,438,594,609.01	156,209,764.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	427,470,415,468.11	609,659,742,135.90
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	309,525,549,817.94	354,354,336,877.13
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	310,265,039.96	426,967,958.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	3,164,944.44	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	117,631,435,665.77	254,878,437,300.77
1.2	Мөнгөн зарлагын дүн	419,460,046,467.48	604,103,778,403.75
1.2.1	Ажиллагчдад төлсөн	29,630,032,299.49	32,162,929,916.94
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,210,672,737.29	10,185,881,303.51
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	12,858,814,885.36	11,565,767,411.03
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	615,881,019.84	582,505,502.90
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,450,088,507.70	1,869,434,121.33
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	751,583,887.42	1,017,597,576.78
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,116,899,312.00	9,609,670,536.34
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,025,074.00	240,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	355,825,048,744.38	537,109,752,034.92
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,010,369,000.63	5,555,963,732.15
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	191,316,700.87	147,521,794.83
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	191,316,700.87	147,521,794.83
2.2	Мөнгөн зарлагын дүн	3,767,491,786.00	20,369,851,219.08
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,767,491,786.00	20,369,851,219.08
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,576,175,085.13)	(20,222,329,424.25)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	14,086.81	13,972,128,259.21
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	13,972,026,882.94
3.1.4		14,086.81	101,376.27
3.2	Мөнгөн зарлагын дүн	2,352,116,419.45	2,352,092,031.66
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,352,082,366.24	2,352,082,366.24
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,352,082,366.24)	11,620,036,227.55
4	Валютын ханшийн зөрүү	(34,053.21)	(9,654.42)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,082,091,582.86	(3,046,329,464.55)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	2,843,632,147.17	4,925,723,730.03
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	4,925,723,730.03	1,879,394,265.48

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2016 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	80,764,538,429.43	50,416,130,722.15	20,981,223,410.32	8,260,824,855.18	160,422,717,417.08
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(4,210,507,159.85)	(4,210,507,159.85)
2	Залруулсан үлдэгдэл	80,764,538,429.43	50,416,130,722.15	20,981,223,410.32	4,050,317,695.33	156,212,210,257.23
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,438,594,609.01	3,438,594,609.01
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(1,660,258,000.00)	(1,660,258,000.00)
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	17,980,348,319.07	-	17,980,348,319.07
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(532,902,841.59)	-	532,902,841.59	-
8	2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	80,764,538,429.43	49,883,227,880.56	38,961,571,729.39	6,361,557,145.93	175,970,895,185.31
2	Залруулсан үлдэгдэл	80,764,538,429.43	49,883,227,880.56	38,961,571,729.39	6,361,557,145.93	175,970,895,185.31
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	156,209,764.00	156,209,764.00
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(343,859,460.00)	(343,859,460.00)
5	Өмчид гарсан өөрчлөлт	(4,513,231.11)	(252,566,945.08)	5,409,494,689.22	170,702,132.61	5,323,116,645.64
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(430,651,547.78)	2,119,376,500.00	-	1,688,724,952.22
8	2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	80,760,025,198.32	49,200,009,387.70	46,490,442,918.61	6,344,609,582.54	182,795,087,087.17

4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшингийн гүйцэтгэлийн тайлан
Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлтүүд	ХЭМЖИХ НЭГЖ	2017 он	2018 он		Төлөвлөгөө/гүйцэтгэл		2018/2017 онуудын гүйцэтгэлийн харьцуулалт	
			Гүйцэтгэл	ТӨБЗГ 674 тогтоол	Гүйцэтгэл	6=5-2	7=5/2	6=5-2	7=5/2
	А	1	2	3	5	6=5-2	7=5/2	6=5-2	7=5/2
1	Худалдаж авах цахилгаан	сая.кВтц	2,660.90	2,726.35	2,934.62	208.27	107.64%	273.72	110.29%
2	ЦЭХ-ний алдагдал: хувиар	хувь	15.79%	15.85%	15.19%	(0.01)	95.86%	-0.6%	96.20%
	биетээр	сая.кВтц	420.2	432.06	445.81	13.75	103.18%	25.61	106.09%
3	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая.кВтц	2,240.7	2,294.29	2,488.81	194.52	108.48%	248.11	111.07%
4	Нийт орлого	сая.төг	362,975.7	388,392.60	421,191.37	32,798.77	108.44%	58,215.70	116.04%
	Борлуулалтын орлого	сая.төг	302,268.5	322,093.74	352,311.91	30,218.16	109.38%	50,043.39	116.56%
	Түгээхийн орлого	сая.төг	53,237.9	59,765.70	60,440.38	674.68	101.13%	7,202.47	113.53%
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	7,469.2	6,533.22	8,439.09	1,905.86	129.17%	969.84	112.98%
5	Нийт зардал	сая.төг	358,832.6	386,131.90	420,672.34	34,540.44	108.95%	61,839.78	117.23%
	Үүнээс: ЦЭХ-ний төлбөр	сая.төг	289,886.6	314,325.70	344,288.59	29,962.89	109.53%	54,401.99	118.77%
	- Үйл ажиллагааны зардал	сая.төг	63,880.6	66,406.28	70,934.62	4,528.34	106.82%	7,053.97	111.04%
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	5,065.31	5,399.84	5,449.13	49.30	100.91%	383.82	107.58%
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	4,143.10	2,260.70	519.12	(1,741.58)	22.96%	(3,623.98)	12.53%
	Орлогын албан татвар	сая.төг	704.50	226.07	362.91	136.84	160.53%	(341.59)	51.51%
	Цэвэр ашиг /алдагдал/	сая.төг	3,438.59	1,873.20	156.21	(1,716.99)	8.34%	(3,282.38)	4.54%
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.99	0.99	1.00	0.00	100.46%	0.01	101.03%
8	Нийт авлага	сая.төг	24,617.41	21,887.00	29,222.20	7,335.20	133.51%	4,604.79	118.71%
	Үүнээс: цахилгааны авлага	сая.төг	21,013.43	18,093.90	23,719.68	5,625.78	131.09%	2,706.25	112.88%
	бусад авлага	сая.төг	3,603.97	3,793.10	5,502.50	1,709.40	145.07%	1,898.53	152.68%
9	Нийт өр төлбөр	сая.төг	64,928.18	60,599.00	94,926.80	34,327.80	156.65%	29,998.62	146.20%
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	21,398.79	11,918.80	39,562.60	27,643.80	331.93%	18,163.81	184.88%
10	Хөрөнгө оруулалт, их засвар	сая.төг	9,628.87	14,880.98	15,067.64	186.66	101.25%	5,438.78	156.48%
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди	минут	1,189.60	1,189.6	1,170.10	(19.50)	98.36%	(19.50)	98.36%
12	Ажиллагсадын тоо	хүн	1,918	1,918	1,919	1.00	100.05%	1.00	100.05%
	Цалингийн сан	сая.төг	34,325.80	35,360.0	34,797.01	(562.99)	98.41%	471.21	101.37%
	Дундаж цалин	сая.төг	741,567.0	1,843.6	1,352.7	(490.93)	73.37%	(740,214.33)	0.18%
13	Дундаж үнэ	төгрөг	134.90	140.39	141.56	1.17	100.83%	6.66	104.94%

Аудитын тайлангийн хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/97/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:		Эрчим хүчний яам		Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Гэрээний хугацаа дууссан, гэрээ дүгнэж, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй 223.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 14.2.3-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалттай нийцэхгүй байна	223.3	Зөвлөмж өгөх	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Авлага, өглөг хариуцсан нягтлан бодогч	О.Ариунболд Д.Хулан
2	Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэлтэй 10 харилцагчийн гэрээний хугацаа, ажил үйлчилгээ хийгдээгүй нийт 87.2 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд дансны ангилал буруу бүртгэсэн нь	87.2	Зөвлөмж өгөх	Авлага, өглөг хариуцсан нягтлан бодогч	Д.Хулан

	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “ <i>Үнэн зөв байх</i> ” заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.				
3	Тайлант онд нэмэгдсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг дахин тооцоолоход 34.9 сая төгрөгийн зардлыг илүү, 2.8 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцож, нийт 32.2 сая төгрөгөөр тайлант үеийн зардлыг нэмэгдүүлж, үр дүнг бууруулсан нь ААНОАТ-ын тухай хуулийн 13.10-т “ <i>Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараа улиралын эхний өдрөөс эхлэн тооцно</i> ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “ <i>Үнэн зөв байх</i> ” заалтыг тус тус зөрчсөн байна	32.2	Зөвлөмж өгөх	Үндсэн хөрөнгө хөрөнгө оруулалтын нягтлан бодогч	С.Цэвэлмаа
4	Тус компани нь Нэмэгдсэн өртгийн албан татварт тайлагнах орлого 50.8 сая төгрөгийг / <i>маягт-ТТ03А/</i> 13 дугаар мөр (<i>цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ үзүүлсний орлого</i>)-нд бөөн дүнгээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д “ <i>холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах</i> ” заалттай нийцэхгүй байна.	50.8	Зөвлөмж өгөх	Авлага, өглөг хариуцсан нягтлан бодогч	Д.Хулан
	Зөрчлийн дүн	393.5			

